

УИХ-ын Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн Байнгын хороодын саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

**Зарим зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт,
хүрэх түвшин тодорхойгүй, ихэнхийг нь үйл
ажиллагааны хэрэгжилтээр дүгнэж байгаа нь
биелэлтийг тооцоход хүндрэлтэй байна**

Агуулга

**Тайланг бэлтгэсэн:
ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар**

Захирал Д.Ганбилэг

Аудитын
менежер Х.Баярмаа

V багийн
Ахлах
шинжээч Л.Эрдэнэчулуун
Аудитор З.Ариунзаяа
Шинжээч Б.Саруул
Ш.Энхтайван

I багийн
Ахлах
аудитор С.Сэрчхорол
Шинжээч: Б.Болормаа
Д.Баттулга

II багийн
Ахлах
аудитор Г.Цэдэнбалжир
Шинжээч Ц.Цолмон

IV багийн
Ахлах
шинжээч У.Баярмаа
Шинжээч Ц.Эрдэнэчулуун

2011 оны 4 дүгээр сар

**Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-
аас үзнэ үү. www.mnao.mn**

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 263533 дугаарын утас,
323266 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
стандартын талаархи мэдэгдэл 4

**Бүлэг 1: Үндсэн чиглэлийн төлөвлөлт, түүний
үндэслэл**

Оршил 5

- Үндсэн чиглэлийг боловсруулахад баримтлах дунд хугацааны бодлогын баримт бичиг үгүйлэгдэж байна 5
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй төсөв сайн уялдахгүй байна 6
- Нилээд зорилт, арга хэмжээний шалгуур, хүрэх түвшин тодорхой бус байна 7
- Зарим ТЕЗ үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулаагүй байна . 8
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний бүтэц, агуулгыг боловсронгуй болгох шаардлагатай байна 9

**Бүлэг 2: Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн
тайлагнал ба хяналт, үнэлгээ**

Оршил 11

- Үйл ажиллагааны хэрэгжилтээр дүгнэх аргачлал нь биелэлтийг бодитой тооцоход хүндрэлтэй байна 12
- Зарим ТЕЗ үндсэн чиглэлийн гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна 12
- Зарим арга хэмжээ хариуцан хэрэгжүүлэгчдийн хоорондын уялдаа муугаас хэрэгжээгүй байна 13
- Хугацаа болон гадаад орчны нөлөөллийг бүрэн тооцоогүйгээс зарим зорилт хэрэгжээгүй байна 14
- Санхүүгийн эх үүсвэрийг олж чадаагүйгээс зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна 15

–Үргэлжлэл–

▪ Хэт ерөнхий, гүйцэтгэлийг тооцох боломжгүй арга хэмжээ олон байна	16
▪ Зарим зорилт, арга хэмжээний биелэлтийг холбогдох байгууллага гаргаж ирүүлээгүй байна	16
▪ Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, судалгаа хийгдэхгүй байна	18
▪ Хангалтгүй хэрэгжсэн буюу хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан, гүйцэтгэлийн үр дүнг тооцохгүй байна	19
Дүгнэлт	20
Холбогдох байгууллагын санал:	
Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал ..	21
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос ирүүлсэн санал	22
	23
Саналд өгсөн тайлбар:	
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос ирүүлсэн саналд өгөх тайлбар	24
Зөвлөмж	25
<u>ХАВСРАЛТУУД:</u>	
Хавсралт-1	26
Хавсралт-2	34

Товчилсон үгийн жагсаалт

БОАЖЯ	Байгаль орчин, аялал, жуулчлалын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХЯ	Гадаад хэргийн яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗТБХБЯ	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
МШХХТГ	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ОБЕГ	Онцгой байдлын Ерөнхий газар
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХШХ	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭЗНХҮЧ	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /Үндсэн чиглэл/
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн Байнгын хороодын санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2011 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдлыг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Хамарсан хүрээ

Аудитад Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх болон биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн холбогдох Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн ажлын албадыг хамруулав. Харин хүн хүч, цаг хугацааны боломжоос шалтгаалан Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээ нэг бүрийн биелэлтийг газар дээр нь шалгаж чадаагүй болно.

Арга зүй, стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан биелэлтийн тайланг судлах,
- Холбогдох албан тушаалтантай ярилцаж, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судалгаа хийх, хэрэгжүүлэгч байгууллагын мэргэжилтнүүдээс төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэх асуулга, санал авах,
- Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1. Үндсэн чиглэлийн төлөвлөлт, түүний үндэслэл

Оршил


1.1 УИХ-аас баталсан журамд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг /цаашид “Үндсэн чиглэл” гэх/ “Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн стратеги, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн жилд төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичиг болно” гэж заажээ¹.

1.2 УИХ-ын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор 2010 оны үндсэн чиглэлийг баталж, дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах үүргийг Засгийн газарт өгсний дагуу Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор “Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г баталсан байна.

Үндсэн чиглэлийг боловсруулахад баримтлах дунд хугацааны бодлогын баримт бичиг үгүйлэгдэж байна

1.3 ҮХШХ-ноос 2010 оны Үндсэн чиглэлийн төслийг ҮХЦБ, ЗГҮАХ, яамдын саналд суурилан боловсруулсан байна. Гэвч цаашид эдийн засаг, нийгмийн хөгжил, үр дүнд чиглэсэн дунд хугацааны бодлогын баримт бичиг үгүйлэгдэж байна.

ҮХШХ улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, шинэтгэлийн бодлогыг боловсруулах, Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газар үйл ажиллагааныхаа хүрээнд “Үндсэн чиглэл”-ийг боловсруулах үүрэгтэй.

Хамаарал	Хувилбар	Тайлбар
	<ul style="list-style-type: none"> Урт хугацаанд буюу 15-20 жил хэрэгжих Хөгжлийн үзэл баримтлал 	2007-2021 онуудад хэрэгжих Мянганы хөгжлийн зорилтод суурилсан ҮХЦБ нь урт хугацааны үр дүнд чиглэсэн Үндэсний хэмжээний баримт бичиг юм.
	<ul style="list-style-type: none"> 5 хүртэл жил буюу дунд хугацаанд суурилсан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх хөтөлбөр 	УИХ-аас баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, яамдын бодлого, үйл ажиллагааны зорилт, мастер төлөвлөгөө, бусад төсөл, хөтөлбөрийг эс тооцвол Үндэсний хэмжээний дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөө гэхээр суурь баримт бичиг алга байна.
	<ul style="list-style-type: none"> Богино хугацаанд хэрэгжих Үндсэн чиглэл 	Үндсэн чиглэлийг: "Хөгжлийн тулгуур баримт бичигт үндэслэгдсэн, Засгийн газрын зайлшгүй хэрэгжүүлэх макро-эдийн засаг, салбарын хэмжээний хөгжлийн арга хэмжээг зохицуулсан, үр дүнг илэрхийлсэн агуулга бүхий бодлогын баримт бичиг байх"-аар төлөвлөж байх.

¹ УИХ-ын 2004 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам”-ын 1 дэх хэсэг

1.4 Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах журмын² дагуу төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд эрхлэх асуудлын хүрээнд боловсруулсан төслөө ҮХШХ-нд хүргүүлэн нэгтгүүлж байна.

1.5 ҮХШХ төслийг эцэслэн боловсруулахдаа салбарын яамдтай хэлэлцүүлэг хийдэг гэх боловч түүнийг баримтжуулаагүй байна.

1.6 ҮХШХ төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналуудыг ҮХЦБ, ЗГҮАХ-ийн зорилтуудтай уялдуулах, агуулгын хувьд тусгахад анхаарсан байна.

Тухайлбал:

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээг ҮХЦБ, ЗГҮАХ-ийн зорилтуудтай болон хариуцан хэрэгжүүлэх зарим байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилттой зэрэгцүүлэн авч үзэхэд:

*- НХХЯ-ны хэрэгжүүлэх зорилтоос ҮХЦБ-д хамаарах 17, ЗГҮАХ-тэй холбогдох 21,
- ЗТБХБЯ-ны салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичигт тусгагдсан 56, ҮХЦБ-той хамаарах 11, ЗГҮАХ-тэй холбогдох 35 арга хэмжээ байна.*

1.7 Монгол банк, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний арга хэмжээ нь макро түвшний буюу улсын төсвийн, мөнгө зээлийн, өр, татварын, эрх зүйн шинэтгэл, гадаад худалдааны стратегийн зорилт, мэдээлэл, харилцаа холбооны бодлогын гэх мэтчилэн зорилтуудтай холбогдож байна.

1.8 Засгийн газраас баталсан Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд ТЕЗ-дын хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан бөгөөд Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газраар хэлэлцүүлэх үед зарим агуулгын өөрчлөлтийг эс тооцвол 1.13 дахь заалт болох инфляцийн түвшинг жилийн эцэст 8.0 хувь байлгах зорилт нэмж тусгагдсан бол уг төслийг УИХ-аар хэлэлцэж батлах явцад агуулгын өөрчлөлтөөс гадна 100 гаруй арга хэмжээ нэмж тусчээ.

1.9 Хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын хувьд зорилтыг хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн ч хэрэгжилтэд тавих хяналтын механизм тодорхойгүйгээс салбар хоорондын уялдаа, зохицуулалт сулрах, хариуцлагын тогтолцоо алдагдах нөхцөл бүрдэж байна.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй төсөв сайн уялдахгүй байна

1.10 УИХ-аас Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулийг 2009 оны 11 сарын 27-ны өдөр баталсан бөгөөд Үндсэн чиглэл болон төсвийг хэлэлцэж, батлах үйл явц цаг хугацааны хувьд зэрэгцэн явагджээ.

1.11 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах хөрөнгийн эх үүсвэр нь төсвийн тухай хуулиар батлагдсан санхүүгийн нөөц, түүний хязгаарын хүрээнд тодорхойлогдож байгаа боловч Засгийн газраас баталсан дэлгэрэнгүй төлөвлөгөөнд³ энэ талаар нэг бүрчлэн тусгаагүй байна.

1.12 Зөвхөн жижиг, дунд үйлдвэр, сүүний үйлдвэрлэл, малчдыг дэмжих, үйлдвэрлэл технологийн парк байгуулах, хот тохижуулах зэрэг арга хэмжээнд

² Журмын 2 дахь хэсэг

³ Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"

зарцуулах санхүүгийн эх үүсвэр, нөөцийг тодорхойлсон ба бусад шаардлагатай арга хэмжээний эх үүсвэрийг бүрдүүлэх, шийдвэрлэх, нэн тэргүүнд дайчлах гэх мэтээр хэрэгжүүлэгчдэд нь үүрэг болгожээ.

1.13 УИХ-ын 2009 оны 79 дүгээр тогтоолд⁴ Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг төсөв, хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулах талаар тусгасан боловч төсөв боловсруулахад үндсэн чиглэлийг бус байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг голлон баримталж байна.

1.14 Үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс шаардагдах хөрөнгийн хэмжээ тодорхой бус бөгөөд гагцхүү төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, тэдгээрт шаардагдах хөрөнгийн хэмжээ л батлагдаж байна.

1.15 Үндсэн чиглэлийн зорилтуудыг хангахад зарцуулагдсан хөрөнгийн тооцоо, судалгаа хэрэгжүүлэгч байгууллага болон ҮХШХ-нд алга байна.

Нилээд зорилт, арга хэмжээний шалгуур, хүрэх түвшин тодорхой бус байна

1.16 Үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нэг бүрчлэн тогтоогоогүй, зарим үйл ажиллагааг хэрэгжилтээр нь тооцохоор тусгасан байна. Үүний улмаас биелэлтийг хэмжих, үр дүнг үнэлэхэд бэрхшээл учирч байна.

1.17 Засгийн газраас баталсан 2010 оны үндсэн чиглэлийн дэлгэрэнгүй төлөвлөгөөнд нийт 1040 үндсэн болон дэд зорилт, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ (Хүснэгт №1).

Хүснэгт №1

Үзүүлэлт	Хэмжих нэгж, шалгуур үзүүлэлтийн хувьд				2010 онд хүрэх түвшний хувьд					
	Тооцсон		үйл ажиллагааны хэрэгжилтээр		тооцсон		үйл ажиллагааны хэрэгжилтээр			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь		
Үүнээс:										
Нэг. Макро эдийн засгийн бодлогийн хүрээнд:										
3 зорилт:	Үндсэн арга хэмжээ	49	30	61.2	19	38.8	41	83.7	8	16.3
	Дэд арга хэмжээ тоо	77	39	50.6	38	49.4	64	83.1	13	16.9
Хоёр. Бодит салбарын хөгжлийн бодлогийн хүрээнд:										
6 зорилт:	Үндсэн арга хэмжээ	102	49	48.0	53	51.9	78	76.5	24	23.5
	Дэд арга хэмжээ	85	26	30.6	59	69.4	60	70.6	25	29.4
Гурав. Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлогийн хүрээнд:										
6 зорилт:	Үндсэн арга хэмжээ	88	37	42.0	51	58.0	59	67.0	29	33.0
	Дэд арга хэмжээ	72	18	25.0	54	75.0	64	88.9	8	11.1
Дөрөв. Ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах бодлогийн хүрээнд:										
7 зорилт:	Үндсэн арга хэмжээ	93	28	30.1	65	69.9	55	59.1	38	40.9
	Дэд арга хэмжээ	82	3	3.7	79	96.3	59	72.0	23	28.0
Тав. Гадаад бодлого, батлан хамгаалахын хүрээнд:										
10 зорилт:	Үндсэн арга хэмжээ	72	2	2.8	70	97.2	14	19.4	58	80.6
	Дэд арга хэмжээ	168	4	2.4	164	97.6	77	45.8	91	54.2

⁴ УИХ-ын 2009 оны "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" 79 дүгээр тогтоолын 2 дахь хэсэг

Зургаа. Засаглал, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд:

3 зорилт:	Үндсэн арга хэмжээ	69	14	20.3	55	79.7	21	30.4	48	69.6
	Дэд арга хэмжээ	83	3	3.6	80	96.4	61	73.5	22	26.5
Нийт 6 бүлэг асуудлаар:										
35 зорилт:	Үндсэн арга хэмжээ	473	160	33.8	313	66.2	268	56.6	205	43.4
	Дэд арга хэмжээ	567	93	16.4	474	83.6	385	67.9	182	32.1
Нийт		1040	253	24.3	787	75.7	653	62.8	387	37.2

1.18 Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан нийт 787 арга хэмжээний хэрэгжилтийн хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт, 387 арга хэмжээний хүрэх түвшинг тус бүр үйл ажиллагааны хэрэгжилтээр тооцохоор байна.

1.19 “Үйл ажиллагааны хэрэгжилтээр” биелэлт, хүрсэн түвшинг тооцох арга хэмжээ гэдэгт хууль, шийдвэрийн төсөл, хөтөлбөр, журам, ТЭЗҮ боловсруулах, зохих байгууллагад өргөн барих, хүргүүлэх, сургалт, семинар, хурал, бусад арга хэмжээ зохион байгуулах, ном хэвлүүлэх, стандарт аргачлал нэвтрүүлэх, судалгаа, туршилт хийх, чуулга уулзалтад оролцох, зарим ажлыг эхлүүлсэн, гэрээ хэлэлцээр байгуулсан байх гэх мэт арга хэмжээ тусгагджээ.

1.20 Эдгээрээс нилээд нь Үндсэн чиглэлд заавал тусгах албагүй бөгөөд Засгийн газрын тухайн гишүүн, холбогдох албан тушаалтан өөрсдийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэж болохуйц арга хэмжээ байна.

1.21 Хүрэх түвшний хувьд үйлдвэр, цогцолбор, нэгж байгуулсан байх, барилга, замын ажил эхлүүлсэн, хөгжил эрчимжсэн, эрх зүйн орчин бүрдсэн байх зэрэг шалгуур тогтоосон боловч хэрэгжилтийг дүгнэх аргачлал тодорхой бус байна.

Зарим ТЕЗ үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулаагүй байна

1.22 Засгийн газраас баталсан Үндсэн чиглэлийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлж ирсэн байна. Харин ихэнх ТЕЗ нар хариуцсан асуудлаа хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

1.23 ТЕЗ нар ийм төлөвлөгөөтэй ажиллавал хэрэгжилт хангагдах, нөөцийн ашиглалт, дотоод хяналт сайжрах, тулгамдсан асуудлыг цаг тухайд нь шуурхай шийдвэрлэх зэрэгт тус дөхөмтэй.

1.24 Сангийн яам, ЗТБХБЯ, БОАЖЯ, ХХААХҮЯ, ЭБЭХЯ-наас бусад төрийн захиргааны ихэнх байгууллагууд Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаагүй байна.

- Тухайн жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллаагүй нь уг баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ өөрөө улсын хөгжлийн стратеги болох бодлогын баримт бичиг, ЗГҮАХ болон хэрэгжүүлж байгаа бусад төсөл, хөтөлбөрт суугдсан, мөн хариуцагч байгууллага, яамдын жилийн ажлын төлөвлөгөө, ТЕЗ-даас холбогдох албан тушаалтантай байгуулж буй үр дүнгийн гэрээнд тусгагддаг гэдгээр тайлбарлагдаж байна.
- БОАЖЯ, ХХААХҮЯ үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хариуцах нэгж албадыг тодорхойлсон ч үр дүнгийн гэрээндээ энэ талаар тусгаагүй байна.

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний бүтэц, агуулгыг боловсронгуй болгох шаардлагатай байна

1.25 Үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээний хэрэгжүүлэгч байгууллагыг оновчтой тогтоогоогүй байна.

1.26 Үндсэн чиглэлийн зорилтууд холбогдох сайд, даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байвал хэрэгжилтийг нь хангах боломжтой юм. Харин эрхлэх асуудлын хүрээнд тэр бүр хамаарахгүй, эсвэл онц шаардлагагүй арга хэмжээ байвал хэрэгжүүлэх боломж буурна.

Жишээлбэл:

- НХХ-ийн болон БСШУ-ны сайдын хамтран хэрэгжүүлэх Үндсэн чиглэлийн 18.13-ын “Мэдлэгт суурилсан эдийн засагт хүрэх зорилтыг тодорхой болгох зорилгоор аутсорсингийн үйл ажиллагааг эхлүүлэх, ажиллагсдыг бэлтгэх сургалтыг идэвхжүүлэх” гэсэн үндсэн арга хэмжээ нь зохицуулалт бий болгох гэхээсээ илүү хэрэгжүүлэх механизмд оролцох, гардан хэрэгжүүлэх утгаар томъёологдсон байгаа нь учир дутагдалтай, түүнчлэн эрх зүйн орчныг бий болгох талаасаа үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар БСШУЯ байх нь зохимжтой байна.
- ЗГХЭГ, НХХЯ-ны хамтран хэрэгжүүлэх 18.13.1-ийн “Цахим Монгол” хөтөлбөр, Монгол Улсад мэдээллийн технологийн аутсорсингийн 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэхэд баримтлах чиглэлд туссан зорилтыг хэрэгжүүлэх” гэсэн зорилт, арга хэмжээ нь НХХЯ бус МШХХТГ-ын чиг үүрэгт шууд хамаарах зорилт байна.
- НХХЯ, БСШУЯ хамтран ажиллах 18.13.2-ын “Гадаад болон дотоод аутсорсингийн хүний нөөцийн мэдээллийн бааз бүрдүүлэх” зорилтын хүрээнд мэдээллийн бааз бүрдүүлэхээр байгаа боловч МШХХТГ-ын чиг үүрэгт шууд хамаарах зорилт байхаар байна. НХХЯ-ны хувьд Хөдөлмөрийн төв бирж дээр хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд аутсорсингоор ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг оруулахаар бэлтгэл ажил л хийгдэж байна.
- ЗГХЭГ, БСШУЯ хамтран хэрэгжүүлэхээр 20.17-д “Аутсорсингийн мэргэжилтэн бэлтгэх” асуудал тусгагджээ.

1.27 Түүнчлэн ЭБЭХЯ-ны хэрэгжүүлэх 1.12-т “Улаанбаатар хотын 220, 110 кв-ийн цахилгаан дамжуулах “Их тойруу” сүлжээний ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, газрын тосны итгэмжлэгдсэн лаборатори байгуулах” гэж хэд хэдэн арга хэмжээг нэгтгэжээ.

1.28 Улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд шууд холбогдолгүй, тухайн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж, хэрэгжих боломжтой зарим асуудлыг үндсэн чиглэлд оруулсан байна.

Тухайлбал:

- Тэргүүн шадар сайд болон Шадар сайд, ХХААХҮ-ийн сайдын хамтран хэрэгжүүлэх “Нийтийн хоолны газруудад хоол үйлдвэрлэлийн нэгдсэн технологийг мөрдүүлж ажиллах”, “Хоолны жор, технологи” номыг хоолны нэр, төрлөөр нэмэгдүүлэн боловсруулж 2000 хувь хэвлүүлэх”, Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд Чанарын удирдлагын тогтолцооны бүх шатны баримт бичгүүдийг боловсруулах, дотоод аудит явуулах арга зүйн зөвлөгөө өгөх” зорилт дэвшүүлсэн.
- Зарим байгууллагын үйл ажиллагаатай холбоотой “Төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагын сургалт хариуцсан мэргэжилтний заах арга зүйн сургалт зохион байгуулах”, Олон улсын ба дотоодын аврагчдын болон галын техник, спортын тэмцээнийг зохион байгуулах, оролцох”, “2010 онд зохион байгуулах сургалт, семинарын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх”, “Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах” гэсэн зорилт, арга хэмжээг тусгасан байна.

1.29 Үндсэн чиглэлд төрийн байгууллага гэхээсээ илүү тэдгээрийн дэмжлэгтэйгээр аж ахуйн нэгж, иргэд, төрийн бус байгууллагын санаачлага, идэвхи оролцоотойгоор гүйцэтгэх боломжтой арга хэмжээ ч тусгагдаж байна.

Тухайлбал:

- 10.3.1-ийн “Хот, суурин газарт цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах”,
- 13.27-ийн “Монгол Улсын хүн амын 45 орчим хувь нь суурьшиж байгаа Улаанбаатар хотын хот байгуулалт болон төлөвлөлтийг хотын хүн амыг эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэх, хүний аюулгүй байдал, байгаль орчин, экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах үндсэн зарчимд нийцүүлж “Шинэ Улаанбаатар” хөтөлбөр төслийг боловсруулан хот төлөвлөлтийн шинэ бодлогыг хэрэгжүүлж эхлэн, нийслэл хотыг олон улсын жишигт хүргэхийн тулд “Эрүүл аюулгүй орчин-эхлэл”, “Орон сууцны шинэ хороолол”, “Зам-гүүрэн гарц”, “Хотын гэрэлтүүлэг, тохижилт-эрчим хүч” зэрэг төсөл хэрэгжүүлэх,
- 13.29-ийн 2010 оныг “Үйлчилгээний соёл, чанарын жил” болгох, хот, төв суурин газарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага хүрээлэн байгаа орчноо ногоон байгууламж, гэрэлтүүлэгтэй, цэвэр цэмцгэр болгох.

1.30 Иймд үндсэн чиглэлд тусгах зорилт, арга хэмжээний саналыг холбогдох байгууллагууд сайтар нягталж байх шаардлагатай байна.


Бүлэг 2. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлагнал ба хяналт, үнэлгээ

Оршил

2.1 Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлагнал, үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу тухайн салбарын төрийн захиргааны байгууллага, алба, нэгж дэх мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар, хэлтсийн мэргэжилтнүүд хариуцан гүйцэтгэж байна.

ҮХШХ-ны Мэдээлэл, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс стратеги зорилтын хүрээнд үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, үр дүнг улсын хэмжээнд үнэлгээ өгөх, судалгаа шинжилгээ хийх үүрэгтэй.

2.2 Үндсэн чиглэлийн тайлагнал, үнэлгээний үйл явцыг бүдүүвчилж үзүүлбэл:



2.3 ҮХШХ-ноос ТЕЗ-дын 2010 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг нэгтгэсэн ерөнхий танилцуулгад 35 зорилт, 474 арга хэмжээний урьдчилсан биелэлт дунджаар 80.8 хувьтай байна гэжээ. Үүнээс бодлогын хүрээний үндсэн арга хэмжээний биелэлтийг үзүүлбэл:

1. Макро эдийн засгийн 49 арга хэмжээ 76.3,
2. Бодит салбарын бодлогын 102 арга хэмжээ 76.3,
3. Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлогын 88 арга хэмжээ 81.9,
4. Ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах бодлогын 93 арга хэмжээ 84.8,
5. Гадаад бодлого, батлан хамгаалах хүрээний бодлогын 72 арга хэмжээ 81.4,
6. Засаглал, эрх зүйн шинэчлэлийн 70 арга хэмжээ 82.9 хувийн дундаж биелэлттэй буюу нийт бүрэн биелсэн 171 (36.1%), 90 хувийн биелэлттэй 122 (25.7%), 70 хувийн биелэлттэй 106 (22.4%), 50 хувийн биелэлттэй 42 (8.9%), 30 хувийн биелэлттэй 22 (4.6%), 10 хувийн биелэлттэй 2 (0.4%), хангалтгүй биелэлттэй 9 (1.9%) арга хэмжээ байна.

2.4 Үндсэн чиглэлийг дүгнэх энэхүү аргачилал нь Засгийн газрын түвшинд тохиромжтой байж болох хэдий ч УИХ-ын түвшинд төдийлөн тохирохгүй байна.

Үйл ажиллагааны хэрэгжилтээр дүгнэх аргачлал нь биелэлтийг бодитой тооцоход хүндрэлтэй байна

2.5 Үндсэн чиглэлийн биелэлтийн тайланд дурдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг судлан үзэхэд дараахь байдалтай байна (Хүснэгт №2).

Хүснэгт №2

Д.д	Үндсэн чиглэлийн бүтэц, агуулга	Нийт	Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлт					
			Хэрэгжсэн	Хувь	Дутуу хэрэгжсэн	Хувь	Хэрэгжээгүй	Хувь
1	Макро эдийн засгийн бодлого	49	6	12.2	42	85.7	1	2.0
2	Бодит салбарын хөгжлийн бодлого	101	30	29.7	63	62.4	8	7.9
3	Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого	88	30	34.1	56	63.6	2	2.3
4	Ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах бодлого	93	34	36.6	58	62.4	1	1.1
5	Гадаад бодлого, батлан хамгаалах	72	20	27.8	52	72.2	-	-
6	Засаглал, эрх зүйн шинэчлэл	70	32	45.7	34	48.6	4	5.7
Нийт		473	152	32.1	305	64.5	16	3.4

2.6 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт болон хүрэх түвшинтэй харьцуулан үзэхэд хэрэгжсэн 152, дутуу хэрэгжсэн 305, хэрэгжээгүй 16 арга хэмжээ байна. Хэрэгжсэн болон хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар үзүүлэв (Хавсралт №1, №2).

2.7 Зорилт арга хэмжээний хэрэгжилтийн нилээдийг үйл ажиллагааны хэрэгжилтээр, тухайн арга хэмжээг хариуцсан салбарынхан өөрсдөө дүгнэн гаргаж байгаа, ҮХШХ-ны хариуцсан ажилтнууд тэдгээрийг нэг бүрчлэн газар дээр нь шалгаж танилцан дүгнэлтийг баталгаажуулах боломжгүй байгаа зэрэг нь хэрэгжилтийг бодитой дүгнэхэд хүндрэл учруулж байна.

2.8 Төлөвлөгөөнд тусгасан “**Үйл ажиллагааны хэрэгжилтээр**” дүгнэх ажлуудыг үнэлэхэд бэрхшээлтэй учраас шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нарийвчлан тогтоосны үндсэн дээр цаашид үйл ажиллагаанд бус үр дүнд үнэлгээ хийх нь салбарын хувьд илүү үр өгөөжтэй байж болох юм.

Зарим ТЕЗ үндсэн чиглэлийн гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна

2.9 Зарим ТЕЗ үндсэн чиглэлийн биелэлтийг үнэн зөв, бодитой тайлагнаагүй байна.

Тухайлбал:

- МШХХТГ “Өрх бүрт шуудан” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шуудангийн хайрцагаар хангасан байх айл, өрхийн тоог 10000–аар нэмэгдүүлнэ гэж зааснаас дөнгөж 236 айл өрхийг хайрцагаар хангасан байхад хэрэгжилтийг 100 хувь гэж тайлагнасан.

- БСШУЯ Үндсэн чиглэлийн 21.1-ийн “Үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, инновацийн үйл ажиллагааны санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох” зорилтын гүйцэтгэлийг 90 хувиар тайлагнасан боловч гүйцэтгэлээр зөвхөн хуулийн төслийг л боловсруулсан байна.
- Түүнчлэн 20.23-т тусгасан Оюутны дотуур байрны хүрэлцээг сайжруулах, “Оюутны дотуур байр-20000 хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх” зорилтын хэрэгжилтийг 100 хувь гүйцэтгэсэнээр тайлагнасан боловч энэхүү хөтөлбөрийг албан ёсоор батлуулаагүй байна.

2.10 Ихэнх тохиолдолд салбарын онцлогийг харгалзсан хэрэгжилтийг хэмжих аргачлал боловсруулагдаагүй байна.

2.11 Үндсэн чиглэлийн тайлагнал нь асуултад хариулах, ерөнхий цар хүрээгээр үнэлэх, хөтөлбөр, эрх зүйн актын төслийг боловсруулсан буюу эхний шатны ажлууд хийгдсэн, цаашид төлөвлөн ажиллаж байгаа зэрэг үр дүнг бус үйл явцыг голлон тайлбарласан, хэт нуршуу байна.

Зарим арга хэмжээ хариуцан хэрэгжүүлэгчдийн хоорондын уялдаа муугаас хэрэгжээгүй байна

2.12 Хэрэгжилт дутуу хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний хувьд хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин зэрэгтэй уялдахгүй, хариуцагчид хэрэгжилтийг зөрүүтэй тайлагнаж байгаагийн зэрэгцээ өөрийн хариуцсан асуудлын биелэлтийг 100 хувь гэж үзэх, хувь доогуур бол хамтран хэрэгжүүлэгчээс шалтгаалсан гэх явдал анзаарагдаж байна.

Тухайлбал:

- БСШУЯ-ны хэрэгжүүлэх инновацийн чиглэлийн асуудлууд ҮХШХ, БСШУЯ-ны дунд явдгаас хэрэгжилт хангалтгүй байна.
- НХХЯ, БСШУЯ, ЗГХЭГ-ын хамтран хэрэгжүүлэх зарим арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллага тодорхойлогдоогүй, биелэлтийн байдлыг тусдаа гаргаж байгаа бөгөөд зохион байгуулсан ажил, үр дүнгийн мэдээлэл хэрэгжүүлэгч бүрээс ирсний дараа биелэлтийн байдлын үнэлгээ нэмэгдэнэ гэсэн тайлбарыг өгч байна.
- Сангийн яамны зүгээс хэрэгжүүлэх 3.2.2 дахь арга хэмжээний дагуу “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Компаний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг ХЗДХЯ-нд хүргүүлж хэрэгжилт дутуугаар тайлагнасан, харин ХЗДХЯ 3.2.3, 3.2.4, 3.13.2, 3.14-ийн хуулийн төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах, журам боловсруулах ажлын хүрээнд СЗХ, Монгол банкнаас төслөө ирүүлээгүйгээс хэрэгжээгүй гэж тайлагнасан.
- Дурдсан 3.14 дэх арга хэмжээний хувьд Монгол Банкны зүгээс төлөвлөгөөт ажлаа хийж хэрэгжилтээ 100 хувь гэж үнэлсэн байхад ЭБЭХЯ-наас 3 сайдын хамтарсан тушаалаар шинэчилсэн журмыг батлуулахаар ажиллаж байна гэжээ.
- ХХААХҮЯ-наас хэрэгжүүлэх 1.15.2-т тусгагдсан “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн хууль, эрх зүйн орчны хүрээнд зохицуулалтын арга хэмжээ авах” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор зарим ажлууд хийгдсэн ч эцсийн үр дүнг тодорхойлохоор тавигдсан “Бирж” байгуулагдаагүй,
- 1.17.2-т “Технологи дамжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах” гэсэн арга хэмжээний хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан ч зохих шалгуурт хүрээгүй, “хуулийн төсөл боловсруулсан байна” гэсэн шалгуурыг оновчгүй гэж үзсэн нь анхнаасаа тухайн асуудлаарх судалгаа хангалтгүй, төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул байгаатай холбоотой байна.
- 6.35-д “Эргэлтэд ороогүй газар тариалангийн газрыг эргүүлэн хурааж авах” гэсэн

арга хэмжээний хүрээнд ажлын хэсэг байгуулагдаж, ажлын эхлэл байсан ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн орчны хүрээнд ХХААХҮЯ тариалангийн газрыг олгох болон хураан авах эрх зүйн үндэслэл байхгүй гэж үзжээ.

- 6.16.4-ийн “Сүүний үхэр дэд хөтөлбөр боловсруулах” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эхлээгүй, хэрэгжилт хангалтгүй байгааг хариуцах эзнийг оновчтой тогтоогоогүйтэй холбоотой гэж тайлбарлаж байна.
- ХХААХҮЯ-ны хариуцсан 13.28 дахь зорилтын “Хөдөөгийн хөгжил хөтөлбөрийг холбогдох яам, агентлагтай хамтран боловсруулах” төслийг ҮХШХ боловсруулж байгаа тул тус хороонд шилжүүлэх санал өгсөн нь төрийн захиргааны байгууллагуудын зохион байгуулалт, ажлын уялдаа дутмаг байгаагаар холбоотой гэж үзэж байна.

2.13 2010 оны үндсэн чиглэлийн төслийг боловсруулах явцад эдийн засгийн өсөлтийг 7.4 хувь байхаар тооцсон ч урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ний бодит өсөлт 6.1 хувь буюу тооцоолж байсан хэмжээнд хүрч чадаагүй байна (Зураг №1).

Хугацаа болон гадаад орчны нөлөөллийг бүрэн тооцоогүйгээс зарим зорилт хэрэгжээгүй байна



2.14 Хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанаас үл хамаарч Үндсэн чиглэлийн зорилт хэрэгжихгүй тохиолдол байна.

Тухайлбал:

- “Дэлхийн худалдааны байгууллагын Дохагийн үе шатны хэлэлцээг дуусгавар болгох сайд нарын түвшний хэлэлцээнд оролцох” зорилт нь хамтран хэрэгжүүлэгчээс шалтгаалан хэрэгжээгүй,
- АПЕК-ийн гишүүнчлэлийн эрх нээлттэй болоогүй, гишүүн орнуудын дэмжлэгийг авах чиглэлээр яриа хэлэлцээр бүрэн хийгдээгүйгээс хэрэгжээгүй,
- МШХТГ IP/MPLS технологид суурилсан өндөр хурдны сүлжээг 11 аймагт суурилуулах арга хэмжээг БНХАУ-ын зээлийн хүрээнд хийх ёстой байтал Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөс шийдвэр гараагүйгээс бүрэн хэрэгжээгүй гэсэн тайлбар өгч байна,
- ЗГХЭГ “Аутсорсингийн мэргэжилтэн бэлтгэх”-ээр БСШУЯ-тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хамтран гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, хүрэх түвшин болон хэмжих нэгж, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.
- ОБЕГ Улаанбаатар хотод 1000 тоннын багтаамжтай хөргүүрийн аж ахуй /махны зоорь/ байгуулах ажил Газрын зөвшөөрлийг албан ёсны болгох асуудал хүлээгдэж байгаагаас шалтгаалж хэрэгжилт нь хангалтгүй байна.
- БСШУЯ “Эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр гадаадын өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын тоог нэмэгдүүлэх”-ээр гадаадын их, дээд сургуулиудтай гэрээ байгуулсан хэдий ч тухайн оны гүйцэтгэлээр зорилтот дүнд хүрээгүй, он дамжин хэрэгжиж байна.
- ЭБЭХЯ-ны Дархан, Сэлэнгийн бүс нутагт Төмөртэй, Хустай, Баянгол, Төмөртолгой зэрэг төмрийн хүдрийн орд газруудыг түшиглэн хар металлургийн үйлдвэрийн цогцолбор байгуулах гэрээ, хэлэлцээ хийх, ТЭЗҮ-ийг боловсруулах, төмрийн хүдрийг олборлох, баяжуулах үйл ажиллагааг эхлүүлэх зорилт Хустай, Баянголын ордууд стратегийн ач холбогдол бүхий ордуудын жагсаалтад ороогүй учраас төрийн хувь эзэмшлийн талаар гэрээ байгуулах эрх зүйн үндэс бүрдээгүй, Төмөртэй ордын

ашиглалтын тусгай зөвшөөрлийн эзэмшлийн асуудал арбитрын шүүхээр шийдвэрлэгдэж байгаагаас шалтгаалан хэрэгжилт хангагдаагүй байна.

- Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд ОБЕГ-аас Гадаад улс, олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох, хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар ажиллах гэсэн зорилтын 2 ажил болох БНХАУ-ын Иргэний хэргийн яам болон Австрали Улсын Гамшигтай тэмцэх газрын бүтэц, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор гэрээ байгуулах асуудал хэрэгжилт хангалтгүй байхад гаргасан тайландаа өөр бусад ажлын талаар дурдан 100 гэсэн үнэлгээ өгсөн байна.

Санхүүгийн эх үүсвэрийг шийдэж чадаагүйгээс зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна

2.15 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг ТЭЗ нар бий болгох үүрэгтэй ч биелэлт тэр бүр хангагдаагүй байна.

Тухайлбал:

- Зэвсэгт хүчнийг улс орны бүтээн байгуулалтад оролцуулах ажлын хүрээнд 120 дугаар ангийн 200 гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчийн байр барих арга хэмжээний зардлыг 2010 оны төсөвт суулгуулан батлуулаагүйгээс хэрэгжээгүй;
- Шилэн кабелийн сүлжээнд хамрагдаагүй 70 сумдыг холбох зорилт төсөв хөрөнгийн хүрэлцээ болон БНХАУ-ын зээлийн хөрөнгийн асуудал шийдэгдээгүйгээс бүрэн хийгдээгүй;
- Интернет протоколд суурилсан өгөгдөл дамжуулах сүлжээг 110 сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 60 сумдад хэрэгжүүлээгүй;
- ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах зорилт, арга хэмжээний хүрээнд холбогдох судалгаа хийх санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүйгээс хэрэгжээгүй;
- Улсын хилийн тэмдэглэгээ хийх талаар БНХАУ-ын талд санал тавихад шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүйгээс хэрэгжилт 30 хувьтай;
- ЗГХЭГ-т Эдийн засгийн хөгжлийн дэд бүс болон нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх хот, суурин газрын хөгжлийн стратегийг боловсруулах ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь тухайн ажилд шаардагдах 600.0 сая төгрөгийн санхүүжилт 2010 оны төсөвт тусгагдаагүйтэй холбоотой;
- ОХУ-ын Улсын нөөцийн агентлагийн Сибирийн тойрог дахь салбартай харилцан туршлага солилцох асуудлын хэрэгжилт 60 хувьтай гэсэн боловч ОХУ-ын Улсын нөөцийн агентлагаас зөвшөөрөл аваагүй, санхүүгийн асуудал шийдвэрлэгдээгүй;
- ЗТБХБЯ-ны “Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан төр, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах”, “Улаанбаатар хотод олон улсын төмөр замын буудал барих ТЭЗҮ-ийг боловсруулах”, “Ачаа тээврийн ложистик төвийг Баян-Өлгий аймгийн Улаанбайшинтад барих бэлтгэл ажлыг хангах”, “Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг түшиглэн 10-20 мянган хүн амтай хотуудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж эхлэх”, “Эдийн засгийн хөгжлийн дэд бүс болон нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх хот, суурин газрын хөгжлийн стратегийг боловсруулах”, “Хатгал, Ханх тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” зэрэг арга хэмжээ хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг төсөвт тусгаагүй шалтгаанаар хэрэгжилт хангалтгүй;
- БОАЖЯ-наас хэрэгжүүлэхээр батлагдсан 10.7-ийн үйл ажиллагааны хэрэгжилтээр тайлагнах “Аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах, хадгалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, төвлөрсөн байгууламжийг байгуулах ажлыг эхлүүлэх” арга хэмжээ нь хөрөнгийн асуудлаас болон хэрэгжээгүй бөгөөд 2009 онд ч төлөвлөгдөж байсан;

- ХХААХҮЯ-наас хариуцах 6.30-ын “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвийн 2 хувиас багагүй байхаар тооцож төлөвлөх” гэсэн арга хэмжээ хэрэгжээгүй.

Хэт ерөнхий, гүйцэтгэлийг тооцох боломжгүй арга хэмжээ олон байна

2.16 ЗГХЭГ-ын хариуцсан зорилт 1.1-т “Эдийн засгийн өсөлтийг дэмжих, дэд бүтэц болон үйлдвэрлэлийн томоохон төслүүдийг эхлүүлэх, нийт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн бүтцийг сайжруулах” гэсэн арга хэмжээ хэт ерөнхий, хичнээн хэмжээний хөрөнгө зарцуулж, юуг ямар хугацаанд яаж хийх нь тодорхой бус байна.

Түүнчлэн:

- 15.10-ын “GPS-ийг Улаанбаатар хот, орон нутагт нэвтрүүлэх” арга хэмжээ нь ЗТБХБЯ-ны хариуцах асуудал боловч үндсэн чиглэлд ЗГХЭГ-ын нэр дээр батлагджээ. Гэтэл GPS системийг ашиглан автомашины навигацийн төхөөрөмж, хүргэлтийн үйлчилгээний автомашины мөшгөлтийн үйлчилгээг төрийн оролцоогүйгээр хувийн хэвшлийн байгууллагууд хийсэн байхад үндсэн чиглэлд нэвтрүүлэх гэж оруулсан;
- Үндсэн чиглэлийн 33.1.1, 33.1.2-т тусгасан зорилт арга хэмжээ болох “Төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний стандартыг боловсруулж турших” асуудлын агуулга давхардсан бөгөөд хүрэх түвшин тодорхойгүйгээс хэрэгжилт хангалтгүй;
- ГХЯ гадаад худалдаанд тулгарч буй тарифын бус саад тотгорыг хөнгөвчлөх асуудлаар үндэсний хороо байгуулахад Дэлхийн худалдааны байгууллагын үйл ажиллагаа, олон талт хэлэлцээнд Монгол Улсын баримтлах байр суурь, удирдамжийг боловсруулах, өөрийн улсын эрх ашгийг хангахад чиглэсэн хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх Засгийн газрын ажлын хэсгийн хүрээнд уг асуудлыг боломжтой гэж үзэж байгаа учир үндэсний хороо байгуулах шаардлагагүй гэж үзсэн;
- Монгол банкаас авч хэрэгжүүлэх зарим зорилт, арга хэмжээнээс инфляцийн түвшинг хэт өсгөхгүй байх, зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах арга хэмжээний хувьд зохих ажлуудыг хийж байгаа ч 1 жилийн хугацаанд хэрэгжилтэд үнэлгээ өгөх, тооцох боломж бага;
- Түүнчлэн инфляцийн түвшинг хэт өсгөхгүй байх мөнгө, төсөв санхүүгийн бодлого баримтлах арга хэмжээний хэрэгжилтийн хувьд үндсэн чиглэлийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх үеийн тооцоололтой нийцэж байсан гэж үзэж байгаа ч нийлүүлэлтийн хүчин зүйлс хэрэгжилтийн үр дүнд нөлөөлсөн;
- ЗТБХБЯ-ны Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Хот байгуулалтын салбар “МОН-2301”, Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Дархан хотын усан хангамжийг сайжруулах” төслүүдийн хүрэх түвшинг төсөлд хамрагдах хүний тоогоор төлөвлөсөн ч гүйцэтгэсэн ажлын хэмжээгээр тайлагнасан байна.

Зарим зорилт, арга хэмжээний биелэлтийг холбогдох байгууллага гаргаж ирүүлээгүй байна

2.17 Зарим салбар хариуцсан асуудлынхаа биелэлтийг ҮХШХ-д бүрэн гаргаж ирүүлээгүйгээс хэрэгжилт тодорхой бус байна.

Тухайлбал:

- Хот, тосгоны хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдал, эдийн засгийн хөгжлийн бие даасан байдлыг хангах чиглэлээр УИХ-ын бүтцэд түр хороо байгуулж ажиллуулах (33.14),
- Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх дунд хугацааны хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх (34.2),

- ЗТБХБЯ-ны гаргасан тайланд хийсэн үнэлгээгээр хэрэгжилт дутуу арга хэмжээний тоо 16-аар нэмэгдэж байна. Жишээ нь:
 - Завхан аймгийн нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг үерийн далангийн хамт барьж дуусгах ажлын гүйцэтгэл 4.9 хувь, /2996.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан/ (8.2.1),
 - Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 131.2 км хатуу хучилттай замын дотоод эх үүсвэрийн ашиглалт 8.5 хувь, Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 62 км хатуу хучилттай замын ажил, гүйцэтгэл 45.4 хувь (8.22),
 - Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай замын ажил, гүйцэтгэл 7.7 хувь, /нийт 211.7 км зам/ (8.22),
 - Хануйн голын төмөр бетон гүүр-Халзан бүргэдэй чиглэлийн 59.8 км хатуу хучилттай замын гүйцэтгэл 71.0 хувь (15.1.3, 17.1),
 - Инженерийн шугам сүлжээ, төвлөрсөн ус хангамжийн систем, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил, гүйцэтгэл 19.6 хувь /Өвөрхангай, Хархорин/ ХАА-ны маргаанаас шүүхийн шийдвэрээр ажил зогсоосон (15.4.1.9) зэрэг арга хэмжээг дурдаж болохоор байна.
 - Мөн Дулааны шугам сүлжээний өргөтгөлийн 750.0 сая төгрөгийг орон нутагт эрхийг шилжүүлсэн, нийслэлийн Хан-Уул дүүргийн 1, 11-р хороонд байрлах орон сууцны хороололд 300 мм-ийн цэвэр усны шугам тавих ажлын зураг төсөвгүй, Ус сувгийн удирдах газраас техникийн нөхцөл олгоогүй, ажлын зориулалтыг өөрчлөх санал нь шийдвэрлэгдээгүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ цуцлагдсан буюу хэрэгжилтийн явцад үр нөлөөтэй арга хэмжээ авч чадаагүй байна.

2.18 Төлөвлөгдсөн зорилт, арга хэмжээний хүрээнд эрх зүйн шинэчлэлийн чиглэлээр өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд нь хууль тогтоох байгууллагын шаардлагыг үл хангасан гэж буцаагдах, мөн хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүйгээс жил дамжсан арга хэмжээ цөөнгүй байна.

2.19 СЗХ-ноос дангаар болон, холбогдох байгууллагуудтай хамтран хариуцаж хэрэгжүүлэхээр он дамжиж тусгагдсан хөрөнгө санхүү, даатгал, үнэт цаасны зах зээл, банк бус байгууллагын үйл ажиллагааг зохицуулах зарим эрх зүйн баримт бичгүүд батлагдаагүй байна.

Тухайлбал:

- “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга” болон түүнтэй холбогдон гарах Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах (2006 он);
- “Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах” (2007 он);
- “Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийн төсөл (2007он) ;
- “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах” (2008 он) зэргийг дурдаж болохоор байна.

2.20 Үндсэн чиглэлд тусгагдсан зарим зорилт, арга хэмжээ агуулга, цар хүрээнээсээ хамаараад хэд хэдэн он дамжин хэрэгжихээс өөр аргагүй байх нь цөөнгүй байна.

Тухайлбал:

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн онцлогийг Та тэмдэглэнэ үү?” гэсэн асуулга, судалгааны дүнгээс үзэхэд:		Хувь
2009 оноос	Үндсэн өөрчлөлт гарсан	33.3
	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд бараг өөрчлөлтгүй	41.0
	Огт өөрчлөгдөөгүй буюу давтагдсан	15.4
	Хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд зайлшгүй өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай	10.3
2010 оны Хувьд	Салбарын хувьд хэрэгжих боломжтой	34.2
	Салбарын хувьд хэрэгжилтэд шүүмжлэлтэй хандана	24.4

	<i>Зохих өөрчлөлтийг оны эхэнд хийх шаардлагатай байсан</i>	4.9
	<i>2010 ондоо багтаан хүндрэлтэй зарим зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нөхцөл байдлыг үнэлж судлан агуулга, шалгуур, үнэлэх хэмжүүрийг өөрчлөх зэрэг шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсан</i>	26.8
	<i>Үндсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, үүссэн нөхцөл байдлыг харгалзаж үзэх, түүнийг шийдвэрлэх боломж бололцоо нөөц байгаагүй</i>	9.8
2011 он	<i>2010 онд шийдвэрлэгдээгүй, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ 2011 оны үндсэн чиглэлд давтагдсан</i>	57.1
	<i>2012 оны үндсэн чиглэлд давтагдах хандлагатай</i>	42.9

2.21 Зөвхөн НХХЯ-наас хэрэгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлд туссан зорилт арга хэмжээнээс 12 нь өмнөх онд хэрэгжиж байсан, мөн 2011 оны үндсэн чиглэлд 9 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгаа нь тухайн жилдээ дуусгах боломжгүй хугацаа шаардагдах бодлогын томоохон зорилтууд байна. Үүнээс үзэхэд үндсэн чиглэлийг баримтлан хэрэгжүүлэх хугацааг нь тухайн жилд баригдалгүй тодорхой зааж өгч байх нь зохистой байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, судалгаа хийгдэхгүй байна

2.22 ҮХШХ яамд, агентлагуудаас ирүүлсэн тайланд үндэслэн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үнэлгээ хийж нэгтгэн холбогдох газарт хүргүүлж байна. Харин хэрэгжилтийг газар дээр нь хянаж бодит байдлыг тодруулах, үнэлэх, судалгаа шинжилгээ хийх ажил орхигдож байна. Энэ нь хүн хүчний болон цаг хугацааны боломж нөөцөөс шалтгаалж байна.

2.23 Үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэсэн тохиолдол алга байна.

2.24 Харин зарим яам, агентлагууд албан тушаалтны үр дүнгийн гэрээнд холбогдох арга хэмжээг тусган жилийн эцэст үнэлж байгаа бөгөөд хэрэгжилт дутуу, хангалтгүй тохиолдолд ажилтны үр дүнгийн үнэлгээг бууруулах зэргээр хариуцлагын арга хэмжээг тооцож иржээ.

2.25 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэлтэй гэж асуулгад оролцогсод үзэж байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх ёстой юу? гэсэн асуулгад оролцогсдын:

- 23.7 хувь “Тийм”,
- 21.1 хувь “Тодорхой хэмжээгээр”,
- 55.3 хувь “Хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд зайлшгүй өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай” гэж хариулжээ.

2.26 Түүнчлэн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, стратегийг төлөвлөж, боловсруулах асуудлыг хариуцсан байгууллагын статус, эрх зүйн байдлыг ч тодорхой болгож өгөх шаардлага байна.

2.27 Аудитын явцад санал асуулгад оролцогсдын албан тушаал, чиг үүргийн хамаарлыг авч үзвэл:

Үндсэн чиглэлийг төлөвлөх, боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг тайлагнах үе шатан дахь оролцооны хамаарал:	Албан тушаал буюу Үүнээс;	Хувь
	▪ Үндсэн чиглэлийг анхан шатанд боловсруулах, төлөвлөлтийн үндэслэлийг хариуцах түвшний	57.1
	▪ Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, зохион байгуулалтыг хариуцах түвшний	26.2
	▪ Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд /улс, ард нийтийн хэрэгцээ/ тайлагнал, үр дүнг хариуцах түвшний	16.7

Хангалтгүй хэрэгжсэн буюу хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан, гүйцэтгэлийн үр дүнг тооцохгүй байна

2.28 Үндсэн чиглэлийн төслийг бүтэц, агуулгын хувьд цаашид боловсронгуй болгох, хураангуйлах, батлах, хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах, төлөвлөлт, хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлж тооцох зэрэг асуудлаар шүүмжлэл байгаа ч энэ талаар салбар хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний нэгж, албадаас ямар нэгэн санал, дэвшүүлсэн бодлогын чанартай асуудал алга байна.

2.29 ТЕЗ-дын хариуцсан 16 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Эдгээр нь ихэвчлэн үнэлгээ буурсан, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг бодитой тогтоогоогүй, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр төсөвт тусгагдаагүй, зураг төсөв хийгдээгүй, бэлтгэл ажил хангагдсан ч зохих түвшний байгууллагаас шийдвэр гарахгүй хүлээгдсэн, хариуцан хэрэгжүүлэгчийн ажлын зохион байгуулалт муу гэх мэт шалтгаантай холбоотой байна.

2.30 Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд тавих хяналт тодорхойгүй, болзошгүй эрсдэл, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх судалгааны ажил хийгдэхгүй байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

- Үндсэн чиглэлийг боловсруулахад баримтлах дунд хугацааны бодлогын баримт бичиг үгүйлэгдэж байна.
- Үндсэн чиглэлийн бүтэц, агуулгыг зарим тохиолдолд хэт ерөнхий тодорхойлсноос Засгийн газар, яам, агентлагуудын дунд хугацааны болон жилийн зорилтууд, хийж гүйцэтгэх бараг бүх ажил том, жижиг гэлтгүй тусгагдаж, улмаар баримт бичгийн хэмжээ томорч, хэрэгжилтийг нь зохион байгуулах, хянаж удирдах, биелэлтийг нь тооцоход бэрхшээлтэй болгож байна.
- Үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээний хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оновчтой тогтоогоогүйгээс биелэлтийг бодитой үнэлэх боломжгүй байна.
- Үндсэн чиглэл болон төсвийн хоорондын уялдаа, зохицуулалт хангалтгүй байна.
- Тухайн жилд хэрэгжүүлэх олон арга хэмжээ санхүүгийн эх үүсвэргүй байгаа нь тэргүүлэх зорилтуудыг зөв эрэмбэлж тусгаагүйтэй холбоотой байна.
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэн оноо өгөхөд баримталсан журам нь Засгийн газар Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөнийхөө биелэлтийг яам, агентлагуудаас авч дүгнэхэд зориулагдсан бөгөөд Засгийн газар үндсэн чиглэлийг хэрхэн хэрэгжүүлснийг УИХ-ын түвшинд үнэлж дүгнэхэд уг журамд тодорхойлсон шалгуур үзүүлэлт, аргачилал тэр бүр тохирохгүй байна.
- Үндсэн чиглэлийн биелэлтийг тайлагнах, үнэлж дүгнэх асуудал сайтар журамлагдаагүйгээс зарим зорилт, арга хэмжээний биелэлтийг хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй нь харьцуулж тайлагнаагүй, үр дүнг бус үйл ажиллагааны хэрэгжилтээр гэж явцыг дурдаж хэт нуршсан зэрэг нь биелэлтийг дүгнэхэд хүндрэл учруулж байна.
- Хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтач ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүйгээс зарим зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал:



**МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

20 11 он 05 дугаар сарын 19-ны өдөр

Дугаар Х.27/1005

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Ч.РАДНАА ТАНАА

Аудитын тайлангийн тухай

Танайхаас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд аудит хийсэн тайлан, түүнд Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос өгсөн санал, тайлбартай танилцлаа.

Тайлан дахь үндсэн чиглэлийг төлөвлөх, боловсруулах, гүйцэтгэл болон үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх асуудалтай холбогдуулан гаргасан дүгнэлт, зөвлөмжүүдийг зарчмын хувьд дэмжиж байна.

Засгийн газар улс орны хөгжлийн бодлогын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөх, боловсруулах, батлах болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг сайжруулах зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажлыг эхлүүлээд байна.

Тухайлбал, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулан, түүнд хөгжлийн аливаа бодлогын зорилтыг төлөвлөх, баримт бичгийг улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлийн хүрээг баримтлан бусад бодлого, зорилтуудтай уялдуулж, шаардагдах хөрөнгө, санхүүжилт, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхой тусган боловсруулж байх, тэдгээрийн хэрэгжилтийг явцаар нь бус үр дүнгээр нь үнэлж байх чиглэлээр тусгаад байна.

Түүнчлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж, төлөвлөх, боловсруулах, батлах болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг сайжруулах чиглэлээр санал боловсруулах ажлыг хийж байна.

Эдгээр ажлуудыг гүйцэтгэснээр аудитын тайлан дахь үндсэн чиглэл, түүний хэрэгжилттэй холбоотой шүүмжлэлтэй асуудлуудыг шийдвэрлэх болно.



Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ч.ХҮРЭЛБААТАР

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ҮНДЭСНИЙ ХӨГЖИЛ, ШИНЭТГЭЛИЙН ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр, Утас: 26-59-12, Факс: (976-11) 32-79-14

2011.05.17 № 1/364
танай 2011.05.06 -ны № 475 -т

Санал хүргүүлэх тухай

2011 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 475 тоот албан бичгээр ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д танай байгууллагаас хийсэн аудитын тайлангийн төсөлтой танилцаж дараахь саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлбар 1-ийг үзнэ үү.

1. **Төслийн 1.3-д дахь заалтын хувьд:** Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дунд хугацааны баримт бичиг бөгөөд Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах үндсэн суурь болж өгдөг. Цаашид манай хорооноос эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2011-2016 оны тэргүүлэх чиглэлүүдийн төслийг боловсруулж байгаа бөгөөд энэ баримт бичиг УИХ-аар батлагдаснаар дунд хугацааны хөгжлийн чухал баримт бичиг болно.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

2. **Төслийн 1.15-д дахь заалтын хувьд:** 2010 оны Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах явцад бодлогын матрицид агуулга талаас нь өөрчлөлт оруулж, урт болон дунд хугацааны бодлогын уялдаа, хөрөнгийн эх үүсвэрийг тодотгосноос гадна Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх яам, байгууллагуудыг тусган УИХ-аас үүрэг, хариуцлага хүлээлгэхээр болсон. Үүний дагуу ЗГ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж УИХ-аар батлуулан 2011 оноос мөрдөн ажиллаж байна.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

3. **Төслийн 1.16-д дахь заалтын хувьд:** Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу Үндсэн чиглэлийн төсөлд шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг нэг бүрчлэн тогтоож үйл ажиллагааны хэрэгжилтээр гэсэн шалгуур үзүүлэлтийг хэрэглэхээ больсон. Иймээс Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлт, үр дүнг үнэлэхэд ихээхэн ахиц гарсан.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

4. **Төслийн 1.21-д дахь заалтын хувьд:** Хүрэх түвшний хувьд үйлдвэр, цогцолбор, нэгж байгуулсан байх, барилга, замын ажил эхлүүлсэн, хөгжил эрчимжсэн, эрх зүйн орчин бүрдсэн байх зэрэг шалгуур тогтоосон боловч хэрэгжилтийг үнэлэх аргачлал алга байна гэсэн нь ойлгомжгүй юм. Засгийн газрын 2010 оны 11-р тогтоолын дагуу холбогдох байгууллагууд хяналт-шалгалт, үнэлгээг хийж байгаа болно.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

5. **Төслийн 1.22-д дахь заалтын хувьд:** УИХ-ын 2004 оны 02 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журмыг баталсан. Энэ журмын дагуу холбогдох байгууллагууд төлөвлөгөө гаргаж үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

6. **Төслийн 1.25-д дахь заалтын хувьд:** МШХХТГ нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах агентлаг тул үүнийг төлөөлж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар гэж тусгасан болно.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

7. **Төслийн 1.26-д дахь заалтын хувьд:** Үндсэн чиглэлийн төслийг УИХ-аас баталсны дараагаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулдаг. Тиймээс уг төлөвлөгөөнд хэрэгжилтийг хариуцах яам, байгууллагуудыг нэг бүрчлэн зааж, хариуцуулж өгдөг тул хэрэгжихгүй үлдэх арга хэмжээ гарах үндэслэлгүй юм.

0800931

Тайлбар 1-ийг үзнэ үү.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

Тайлбар 3-ыг үзнэ үү.

Тайлбар 4-ийг үзнэ үү.

8. **Төслийн 1.27-д дахь заалтын хувьд:** Үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг УИХ-ын байнгийн хороогоор хэлэлцэх явцад гишүүдийн зүгээс дэмжлэг авсан зарим саналуудыг найруулгаар нэгтгэж тусгах явдал гардаг.
9. **Төслийн 2.5, 2.6-д дахь заалтуудын хувьд:** Үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бодитой дүгнээгүй байна гэсэн гарчигийн дор орсон 2.5, 2.6 заалтууд нь уг гарчигтайгаа уялдаагүй байна. Тиймээс гарчигийг солих саналтай байна.
10. **Төслийн 2.15-д дахь заалтын хувьд:** Зарим арга хэмжээний биелэлтийн хувийг ҮХШХ хянаж өөрчилжээ гэсэн 4 ажил дурдагдсан ба үүнд дараах тайлбарыг хийж байна.

- Гамигсаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлыг ОБЕГ хийж дуусган Засгийн газраар хэлэлцүүлэхэд бэлэн болсон учир 90 хувь гэж үзсэн боловч ҮХШХ-ноос 40 хувьтай гэж дүгнэсэн;

Тайлбар1. ОБЕГ-ын 2011 оны 1-р сарын 10-ны өдрийн 1/77 тоот албан бичгээр ирүүлсэн тайлангийн 29.1-д тус заалтын биелэлтийг ирүүлсэн бөгөөд тус газраас хэрэгжилтийн хувийг 40 гэж ирүүлсэн байна. Хороо өөрчлөлт оруулаагүй болно.

- ОБЕГ Гамигийн үед хүч, хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журам боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн учир 90 хувийн хэрэгжилттэй гэж үзсэн боловч ҮХШХ-ноос 70 хувь гэж дүгнэсэн;

Тайлбар2. Дээр дурдсан ОБЕГ-ын 1/77 тоот албан бичгээр ирүүлсэн тайлангийн 29.2-д тус заалтын биелэлтийг ирүүлсэн бөгөөд тус газраас хэрэгжилтийн хувийг 90 биш 70 гэж ирүүлсэн байна. Хороо өөрчлөлт оруулаагүй болно.

- Гадаад улс, олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох, хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар ажиллах гэсэн зорилтын 2 ажил болох БНХАУ-ын Иргэний хэргийн яам болон Австрали Улсын Гамигтай тэмцэх газрын бүтэц, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор гэрээ байгуулах асуудал хэрэгжээгүй учир уг асуудлыг 80 хувийн хэрэгжилттэй гэж үзсэн байхад ҮХШХ-ноос 100 хувь гэж дүгнэсэн;

Тайлбар3. Дээр дурдсан ОБЕГ-ын 1/77 тоот албан бичгээр ирүүлсэн тайлангийн 30.2-д тус заалтын биелэлтийг ирүүлсэн бөгөөд тус газраас хэрэгжилтийн хувийг 100 хувь биелсэн гэж ирүүлсэн байна. Хороо өөрчлөлт оруулаагүй болно.

- ХХААХҮЯ-ны хариуцсан 13.28 дахь зорилтын "Хөдөөгийн хөгжил хөтөлбөрийг холбогдох яам, агентлагтай хамтран боловсруулах" төслийг ҮХШХ боловсруулж байгаа тул тус хороонд шилжүүлэх санал өгсөн нь төрийн захиргааны байгууллагуудын зохион байгуулалт, ажлын уялдаа дутмаг байгаатай холбоотой гэж үзэж байна.

Тайлбар4. ХХААХҮЯ-аас боловсруулсан Монгол мал хөтөлбөр, ЗТБХБЯ-аас боловсруулсан Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүдтэй уялдуулан Хөдөөгийн хөгжил хөтөлбөрийн төслийг манай хорооноос удирдан холбогдох яамд, байгууллагууд, суудлаачдын бүрэлдхүүнтэй ажлын хэсгийг байгуулан боловсруулж байна.

Иймээс тайлангийн төсөлд өгч буй дээрх саналуудыг судлан үзэж аудитын тайландаа тодруулга хийнэ үү.

ДАРГА



Ч.ХАШЧУЛУУН

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос ирүүлсэн саналд өгөх тайлбар:**ҮАГ-ын тайлбар 1**

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны 2011 оны 5 сарын 17-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 1/364 дүгээр албан бичгийн 1-ээс 8 хүртэлх хэсэгт дурдсан зүйлүүд нь 2011 оноос гүйцэтгэж байгаа ажлын талаар болон хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой санал байх тул тайлангийн төслийн тухайн хэсэгт өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

ҮАГ-ын тайлбар 2

Саналыг хүлээн авч “Үйл ажиллагааны хэрэгжилтээр дүгнэх аргачлал нь биелэлтийг бодитой тооцоход хүндрэлтэй байна” гэж өөрчлөв.

ҮАГ-ын тайлбар 3

ҮХШХ-ны саналыг хүлээн авч Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газарт хамаарч байгаа 29.1, 29.2 дахь арга хэмжээний хэрэгжилтийн талаархи уг хэсгийг тайлангаас хасав.

Харин 30.2 дахь үндсэн арга хэмжээний хүрээнд хийгдэх 30.2.2, 30.2.3 дахь дэд арга хэмжээний хэрэгжилтийн талаар ОБЕГ тайландаа дурдаагүй атлаа өөр бусад ажлын тухай тайлагнан 100 гэсэн үнэлгээ өгсөн байна. Иймд уг 2 дэд арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй учир тайлангийн агуулгатай тохирч байгаа 2.14 дахь хэсэгт оруулав.

ҮАГ-ын тайлбар 4

Тайлангийн энэ хэсэг нь ҮХШХ-ноос хийж буй ажилд хамааралгүй бөгөөд 13.28 дахь зорилтын талаар хэрэгжүүлэгч байгууллагаас уг саналыг өгсөн байна. Тус хэсгийг агуулгын хувьд тохирч байгаа 2.12 дахь хэсэгт оруулав.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод:

- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад баримтлах нийгэм, эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн төсөл боловсруулж, зохих журмын дагуу батлуулж, мөрдүүлэх,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хөрөнгө зайлшгүй шаардагдах зорилт, арга хэмжээний санхүү, хөрөнгийн эх үүсвэрийг нэгдсэн төсөв, бусад эх үүсвэртэй уялдуулах механизм бүрдүүлэх,
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн дагуу товч тодорхой тайлагнаж байх,
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, тайлагналд тавих дотоод хяналтыг боловсронгуй болгох санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуунд:

- Үндсэн чиглэлийн төлөвлөлтөд мэргэшсэн шинжээчдийг оролцуулах, салбарын яамдтай хийх зөвшилцөл, хэлэлцүүлгийг баримтжуулах, хэт олон бус, улс орны хэмжээний тэргүүлэх ач холбогдол бүхий томоохон, тодорхой үр дүнд чиглэсэн зорилт, арга хэмжээг тусгаж байх,
- Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, хэмжих нэгж, шалгуур, хүрэх түвшинг холбогдох байгууллагуудтай хамтран тодорхойлж, оновчтой томъёолж байх,
- Үндсэн чиглэлийг бүтэц, агуулга, хэрэгжих хугацааны хувьд боловсронгуй болгох санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй нь харьцуулан хянаж баталгаажуулсны үндсэн дээр нэгтгэж, гүйцэтгэлийг сайтар тооцож байх,
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, дүнг Засгийн газарт танилцуулан, холбогдох арга хэмжээ авахуулж байх.

Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Үндсэн чиглэлийн бүтэц, агуулгыг нарийвчлан тодорхойлж, Үндсэн чиглэлд тусгах шаардлагатай болон шаардлагагүй асуудал, арга хэмжээнүүдийг зааглаж өгөх,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтийг УИХ-ын түвшинд үнэлж дүгнэхэд баримтлах шалгуур үзүүлэлт, аргачлалыг тогтоож мөрдүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилтын дугаар	Зорилт, арга хэмжээ	Хариуцан хэрэгжүүлэгч
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
1	2.2	Олон улсын валютын сантай тохиролцсон тогтворжилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, зээлийн хөрөнгийг оновчтой ашиглах;	Сангийн сайд
2	2.5	Төсвийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай, Нэгдсэн төсвийн тухай хуулийн төслүүдийг боловсруулах;	Сангийн сайд
3	2.15	Хилийн боомтуудыг өргөтгөн тохижуулж, хяналтыг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх, ложистик терминал барих, хилийн боомтод ажиллах гаалийн улсын байцаагчдын ажиллах нөхцөл, орон сууцны асуудлыг шийдвэрлэх;	Сангийн сайд, ХЗДХ-ийн сайд
4	3.4	Монгол Улсын зээлжих зэрэглэлийг шинэчлэн тогтоолгох чиглэлээр олон улсын нэр хүнд бүхий байг-дтай хамтран ажиллах;	Сангийн сайд
5	3.6	Даатгалын зах зээлийн хөгжлийг дэмжиж, түүний нийгэмд үзүүлэх үр нөлөөг өргөжүүлэх хүрээнд "Малын индексжүүлсэн даатгал" төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх;	Сангийн сайд
6	3.11	ЗГСУМС-д бүх сумыг холбох;	Сангийн сайд
БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
7	5.9	Ховд, Увс аймгийн төвд дулааны шинэ эх үүсвэр барих асуудлыг судалж шийдвэрлэх;	ЭБЭХ-ний сайд
8	6.3	Мал, амьтны тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах замаар МАА-г аливаа эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлэх, отрын бүс нутгийг хамгаалах	ХХААХҮ-ийн сайд
9	6.5	Хүн амын усан хангамжийг сайжруулах зорилгоор сум бүрт 5-аас доошгүй /баг бүрт 1/ худаг гаргаж хөдөөгийн хүн ам, мал аж ахуйг усаар хангах, бэлчээрийг усжуулах, иргэдийн оролцоотойгоор хөв, цөөрөм байгуулах, гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжиж, газар доорх усны геофизикийн хайгуул судалгаа хийх	ХХААХҮ-ийн сайд
10	6.7	Малын халдварт болон паразиттах өвчний гаралтыг бууруулах, зарим халдварт өвчнөөс эрүүлжүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг сайжруулах, "Бруцеллёзоос эрүүлжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Завхан, Сүхбаатар аймагт хэрэгжүүлэх, хөрөнгийн дотоод эх үүсвэрийг шийдвэрлэх	ХХААХҮ-ийн сайд
11	6.8	Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийн үйл ажиллагааг дэмжих, эмчилгээ, үржлийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах, оношлогооны чадавхийг дээшлүүлэх	ХХААХҮ-ийн сайд
12	6.11	Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийж, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, дундын техник засварын үйлчилгээний нэгж байгуулах	ХХААХҮ-ийн сайд
13	6.12	Таримал ургамлын үр үржүүлгийн үндэсний төвийг байгуулах	ХХААХҮ-ийн сайд
14	6.14	Хөрсний үржил, шимийг дээшлүүлэх, нэгжээс хураан авах ургацыг нэмэгдүүлэх, бордооны үйлдвэрлэлийг дэмжих	ХХААХҮ-ийн сайд
15	6.15	Хүн амын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн жимс, жимсгэний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж "Чацаргана" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нийслэлийн иргэдийг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах зорилгоор өвлийн иж бүрэн хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлэх	ХХААХҮ-ийн сайд
16	6.23	Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг шинжлэх шинэ арга, аргачлалыг лабораторийн шинжилгээнд нэвтрүүлэх	ХХААХҮ-ийн сайд
17	6.24	Соггууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж, гаргасан санал дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авах	ХХААХҮ-ийн сайд
18	6.25	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн стандартуудыг шинэчилж, хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг холбогдох стандартад тусгах	ТШ Сайд, ХХААХҮ-сайд

19	6.26	МАН-н салбарт олон улсын стандартын шаардлагыг хангасан эрүүл ахуй, чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлж мал аж ахуйн гаралтай хүнс, түүхий эд болон бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг 40-өөс доошгүй хувиар нэмэгдүүлж малчдын орлого, амьжиргааны түвшинг тогтвортойгоор дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд хоёр хөрш, бусад хөгжилтэй орнуудтай хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хорио цээрийн хэлэлцээрийг байгуулж, холбогдох шаардлага, болзол, нөхцөлийг бүрдүүлэх	ХХААХҮ-ийн сайд
20	6.27	Мал эмнэлэг, үржлийн хяналтыг орон нутагт нэгдсэн удирдлага, зохион байгуулалттай хэрэгжүүлэх санал боловсруулах	ХХААХҮ-ийн сайд
21	6.31	Малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах болон бэлчээр усжуулалт, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, мал эмнэлэг, үржлийн албаны шинэ тогтолцоог бий болгох зэрэг асуудлыг цогцдоор нь тусгасан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх замаар мал аж ахуйн түүхий эдийг зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бий болгох	ХХААХҮ-ийн сайд
22	7.3	Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг хадгалах орчин үеийн дэвшилтэт техник технологи бүхий төрийн өмчийн агуулахыг шинээр барьж байгуулах	ЭБЭХ-ний сайд
23	8.6	Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай авто замыг төсвийн болон эргэн төлөгдөх нөхцөлөөр барьж эхлэх;	ЗТБХБ-ын сайд
24	8.7	Нислэг хөдөлгөөний бодит ажиглалтын систем, газрын навигацийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх ажлыг үргэлжлүүлэн, хангалтыг сайжруулах;	ЗТБХБ-ын сайд
25	8.8	Шинэ төмөр зам тавих, төмөр замыг цахилгаанжуулах ТЭЗҮ-ийг боловсруулах, ажлыг эхлүүлэх, төмөр замын одоо мөрдөж байгаа олон улсын гэрээ хэлэлцээрийг хуульд нийцүүлэн шинэчлэх, төмөр замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх үндэсний стратеги бодлогыг боловсруулж батлах, хэрэгжүүлж эхлэх, “Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг боловсруулж Улсын Их Хурлаар батлуулах	ЗТБХБ-ын сайд
26	8.9	Төмөр замын салбарт төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүний паркыг нэмэгдүүлэх	ЗТБХБ-ын сайд
27	8.11	Улаанбаатар хот орчимд ачааны /чингэлэгийн/ терминал барих ТЭЗҮ-ийг боловсруулах;	ЗТБХБ-ын сайд
28	8.18	Улаанбаатар хот болон томоохон суурин газрын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан, багтаамж ихтэй тээврийн хэрэгслээр хангах;	ЗТБХБ-ын сайд
29	8.28	Улс, орон нутгийн чанартай авто замын урсгал засвар, авто замын арчлалтын ажлыг орон нутгийн иргэдээр гэрээ болон түрээсийн хэлбэрээр хийлгэх замаар ажлын байр шинээр бий болгож, иргэдийг нэмэгдэл орлоготой болгох;	ЗТБХБ-ын сайд
30	8.30	Нарийнсухайт-Шивээхүрэнгийн төмөр зам, хатуу хучилттай авто замыг барьж байгуулах;	ЗТБХБ-ын сайд
31	8.36	Хот тохижилтод зориулан 5.0 тэрбум төгрөг зарцуулах;	Сангийн сайд
32	8.37	Хотын замын сүлжээний туслах болон явган зорчигчийн замыг сайжруулах ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх;	Сангийн сайд, ЗТБХБ-ын сайд
33	8.38	Хүн амыг орон сууцжуулж, түүнд шаардагдах дэд бүтцэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.	ЗТБХБ-ын сайд
34	9.3	ЗИП кодыг улсын хэмжээнд бүрэн нэвтрүүлэх	ЗГХЭГ-ын дарга
35	9.4	Улаанбаатар хотод тоон телевиз нэвтрүүлэх	ЗГХЭГ-ын дарга
БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
36	10.1	Нийслэлийн агаарын чанарын хяналт шинжилгээний сүлжээг байгуулж, ашиглалтад хүлээн авах, үйл ажиллагааг эхлүүлэх	БОАЖ-ын сайд
37	10.2	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг дэмжиж, урамшуулах: Агаарын тухай багц хууль түүнтэй холбогдох татварын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах,	БОАЖ-ын сайд
38	10.4	Гол, мөрний бохирдлыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлж, булаг, шанд, гол, горхины эхийг хамгаалж, тохижуулах	БОАЖ-ын сайд
39	10.7	Аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах, хадгалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, төвлөрсөн байгууламжийг байгуулах ажлыг эхлүүлэх	БОАЖ-ын сайд

40	10.8	Уур амьсгалын өөрчлөлтийн хандлагыг үнэлэх, удаан хугацааны прогноз гаргах ажиллагааг шинэ технологид шилжүүлэх	БОАЖ-ын сайд
41	10.12	Монгол Улсын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Сэлэнгэ мөрний сав газарт усан сан байгуулах болон Эгийн голд усан цахилгаан станц барих асуудлыг судлах;	БОАЖ-ын сайд
42	11.6	Ойн ногоон зурвас болон ойжуулалтын ажилд шаардагдах үр, тарьц, суулгацын тогтвортой нөөцийг бүрдүүлэх;	БОАЖ-ын сайд
43	11.7	Ойн хортон шавьжтай тэмцэх ажлын хэмжээг нэмэгдүүлж, түймрээс урьдчилан сэргийлэх чадавхийг сайжруулах	БОАЖ-ын сайд
44	11.8	Цөлжилтөөс сэргийлэх, хөрс хамгаалах эрх зүйн орчныг бий болгон цөлжилттэй тэмцэх сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх	БОАЖ-ын сайд
45	11.10	Өндөр уулын болон уулын тайгын бүслүүрийн ашиглалтад өртөмтгий, ашигт ургамлын тархац, нөөцийг тогтоох;	БОАЖ-ын сайд
46	11.12	Өмнө нь улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалтын менежментийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах зорилгоор Архангай аймагт ус намгархаг газрын судалгаа, сургалтын иж бүрэн төвийг ашиглалтад оруулан, Улаанбаатар хотын Богдхан ууланд Байгаль орчны эрдэм шинжилгээ, судалгааны цогцолбор төвийг байгуулах ажлыг эхлүүлэх;	БОАЖ-ын сайд
47	12.3	Аялал жуулчлалын статистик бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээг сайжруулах;	БОАЖ-ын сайд
48	13.2	Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжих “Говийн өмнөд бүсийн хот байгуулалт, хилийн боомтын хөгжлийн төсөл”-ийн хэлэлцээр байгуулах;	Сангийн сайд, ЗТБХБ-ын сайд
49	13.9	Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг баримтлан орон нутгийн түүхий эд, боломж, нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	ХХААХҮ-ийн сайд
50	13.11	Буянт-Ухаагийн орон сууцны хороолол, Яармагийн орон сууцны шинэ хорооллын инженерийн дэд бүтцийг барих ажлыг эхлүүлэх;	ЗТБХБ-ын сайд
51	13.12	“Орон сууцны XIV хороолол”, “Орон сууцны VII хороолол”, “Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз орчмын хороолол”-ын инженерийн дэд бүтцийг барих ажлыг эхлүүлэх;	ЗТБХБ-ын сайд
52	13.15	Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Дархан хотын усан хангамжийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх;	ЗТБХБ-ын сайд
53	13.20	Хот болон аймгийн төвүүдийн гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах төслийг боловсруулж, гэр хорооллын доторхи зам, цэвэр усны шугам, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх ажлыг үргэлжлүүлэх;	ЗТБХБ-ын сайд
54	13.21	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн технологийг шинэчлэх;	ЗТБХБ-ын сайд
55	13.22	Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;	ЗТБХБ-ын сайд
56	13.23	Барилгын арматур, төмөр хийц, дулаан тусгаарлах материал, шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх;	ЗТБХБ-ын сайд
57	13.24	Бүсийн тулгуур төв болон хилийн боомтуудад барилгын материалын лабораторийг тоноглох тоног төхөөрөмжийг судалж тогтоох;	ЗТБХБ-ын сайд
58	13.25	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шатыг шинэчилж солих ажлыг эхлүүлэх;	ЗТБХБ-ын сайд
59	14.8	Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, шилдэг техник, технологи нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг урамшуулах механизм бүрдүүлэх	ЭБЭХ-ний сайд
60	14.12	Уул уурхай-металлурги-эрчим хүчний иж бүрэн цогцолборуудыг дагасан хангамж, үйлчилгээ, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийн цогц систем байгуулахыг дэмжих	ЭБЭХ-ний сайд
61	14.13	Гар аргаар ашигт малтмал олборлох эрх зүйн орчныг бүрдүүлэх	ЭБЭХ-ний сайд
62	15.2	Орон нутаг, томоохон хот, суурин газруудын засаг захиргааны байгууллагуудыг төрийн нэгдсэн мэдээллийн сан, сүлжээнд холбож, үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх	ЗГХЭГ-ын дарга
63	15.6	Улаанбаатар хотын 41 салбар, 21 аймаг, 118 сумын шуудангийн салбарыг нэгдсэн сүлжээнд холбосон мэдээлэл технологийн төв байгуулах	ЗГХЭГ-ын дарга

64	15.7	Сансрын холбооны системийн давтамжийн зурвасыг үр ашигтайгаар ашиглан, газрын станцуудын тоног төхөөрөмжийг шинэчилж, орон нутгийн телевизийн станцийг өргөтгөн телевизийн 10 суваг нэвтрүүлэх	ЗГХЭГ-ын дарга
65	15.8	Бүх сумыг шилэн кабельд холбох замаар үндсэн суурь сүлжээг бүрхэх хүртээлтэй болгон, гар утас, интернетийн үйлчилгээг хүргэх;	ЗГХЭГ-ын дарга
66	15.10	GPS-ийг Улаанбаатар хот, орон нутагт нэвтрүүлэх	ЗГХЭГ-ын дарга
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО			
67	16.1	Нийтийг хамарсан нийгмийн халамжийн тэтгэмж, дэмжлэг, тусламжийг нийгмийн зорилтот бүлгүүд болон нийгмийн халамж хүртэх шаардлагатай хэсэгт чиглүүлж шинэчлэл хийх;	НХХ-ийн сайд
68	16.2	Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуу өрхөд чиглэсэн салбар дундын үйл ажиллагаагаар хүргэх зохион байгуулалтын арга зүйг нэвтрүүлэн эрүүл мэнд, боловсрол, бичил хоол тэжээл, хоол тэжээлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;	НХХ-ийн сайд
69	16.3	Стратегийн ач холбогдол бүхий болон томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчныг бүрдүүлж, үе шаттай хэрэгжүүлж эхлэх;	НХХ-ийн сайд
70	16.4	Халамжийн үйлчилгээний зохион байгуулалт, менежментийг сайжруулж, түүнд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах;	НХХ-ийн сайд
71	16.5	Хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэн батлуулж, уг аргачлалын дагуу ядуу өрхүүдийн мэдээллийн сан бүрдүүлэх;	НХХ-ийн сайд
72	16.11	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамжийн тогтолцоог өөрчилж, нийгмийн тодорхой бүлэгт хандсан нийгмийн халамжийн ялгавартай бодлогыг авч хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох.	НХХ-ийн сайд
73	18.10	Ажлын байр нэмэгдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг эдийн засгийн механизмаар дэмжих эрх зүйн орчныг бий болгох талаар санал боловсруулах;	НХХ-ийн сайд
74	18.11	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоог нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрыг түшиглэсэн түргэвчилсэн сургалтаар мэргэжил олгох тогтолцоог урамшуулан дэмжиж, мэргэжлийн зөрүүгээс ажилгүйдэл үүсэх шалтгааныг бууруулах;	НХХ-ийн сайд
75	18.12	Гадаадаас авч байгаа ажилчидтай ижил мэргэжлийн ажилчдыг дотооддоо бэлтгэх, зам, барилга, уул уурхай, үйлдвэр барих зэрэг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төслүүд дээр монгол ажилчдыг ажиллуулах зорилгоор мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд түргэвчилсэн сургалтаар мэргэжил эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах;	НХХ-ийн сайд, БСШУЯ-ны сайд, ЭБЭХЯ-ны сайд
76	19.1	ЭМ-ийн боловсрол олгох, эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх, мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг үндэсний түвшинд арга зүйгээр хангах тогтолцоог бүрдүүлэх;	ЭМ-ийн сайд
77	19.2	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, сангийн үр ашгийг нэмэгдүүлэхтэй уялдуулан иргэний эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн үндэсний эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эмнэл зүйн удирдамж, стандартыг боловсруулах;	ЭМ-ийн сайд
78	19.3	Төлбөрийн чадваргүй, хүн амын амьжиргааны түвшингээс доогуур орлоготой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлгийн тусламж хөнгөлөлттэй үнээр олгох тогтолцоог судалж, хэрэгжүүлэх;	ЭМ-ийн сайд
79	19.6	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцэхүйц эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх;	ЭМ-ийн сайд
80	19.7	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх 4 дүгээр шатны төслийн хэлэлцээр байгуулах;	ЭМ-ийн сайд

81	19.9	Сум, өрхийн эмчийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо болон орон нутагт ажиллах эмч нарын урамшууллыг боловсронгуй болгох замаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмчийн хангалтыг сайжруулах;	ЭМ-ийн сайд
82	19.10	Эрүүл мэндийн үйлчилгээнд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтуудыг нэвтрүүлж, улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зайны оношилгооны цахим эмнэлгийн нэгдсэн сүлжээг бий болгох;	ЭМ-ийн сайд
83	19.12	Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бодисын чанарыг баталгаажуулах сорилын лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх замаар эмийн хангамж, хяналтыг сайжруулж, эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд чанарын баталгаажилт, лавлагаа хийх чадавхийг бэхжүүлэх;	ЭМ-ийн сайд
84	19.13	Малчин, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг нөхөн үржихүйн эм, хэрэгслээр тогтвортой хангах;	ЭМ-ийн сайд
85	19.15	Аймгийн нэгдсэн эмнэлэгийн төрөх хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулах	ЭМ-ийн сайд
86	19.16	Өсвөр насны охид, жирэмсэн эмэгтэйчүүд, ураг, нярай болон хүүхдийн эрүүл мэндийн тусламжийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор нэг цэгийн цогц үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх;	ЭМ-ийн сайд
87	19.21	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн шинэ барилгын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийн нэн шаардлагатай өндөр чадлын техник, технологи, багаж, тоног төхөөрөмжөөр хангах;	ХЗДХ-ийн сайд
88	20.3	Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэн 4-7, 9-12 дугаар ангийн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан тохирцыг үнэлж, сургалтад мөрдүүлэх;	БСШУ-ны сайд
89	20.6	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлэх, түгээх ажлыг хичээлийн жилийн өмнө зохион байгуулж, сурах бичгийн хүрэлцээ, хангамжийг сайжруулах;	БСШУ-ны сайд
90	20.7	Ерөнхий боловсролын сургуулийн компьютерийн тоог нэмэгдүүлж, багш нарыг зөөврийн компьютерээр хангах арга хэмжээг үргэлжүүлэх;	БСШУ-ны сайд
91	20.9	Сургууль завсардалтыг бууруулж, бүх хүүхдэд бага боловсрол олгох;	БСШУ-ны сайд
92	20.10	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үйлчилгээг хүргэх төсөл”-ийг эхлүүлэх;	БСШУ-ны сайд
93	20.12	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багшийн хангамж, мэргэжлийн чадавхи, ур чадварыг дээшлүүлэх;	БСШУ-ны сайд
94	20.14	Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулах;	БСШУ-ны сайд
95	20.16	“Дээд боловсролын шинэчлэл 2010-2012” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж эхлэх;	БСШУ-ны сайд
96	20.17	Аутсорсингийн мэргэжилтэн бэлтгэх	ЗГХЭГ-ын дарга
97	20.24	Математик болон байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийг аймаг, дүүрэг бүрт нэгийг алсын зайн сургалтыг ашиглан зохион байгуулж ажиллуулах;	БСШУ-ны сайд
98	21.5	Дэвшилтэт технологи хөгжүүлэх талаар их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлыг дэмжих;	БСШУ-ны сайд
99	21.6	Хүн, мал эмнэлгийн салбарт оношилогоо, эмчилигээний вакцины дотоодын хэрэгцээг хангах үйлдвэрлэл-технологийн үндсийг тавих	ХХААХҮ-ийн сайд, ЭМ-ийн сайд
100	22.5	Соёл, урлагийн байгууллагын материаллаг бааз, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг, ном, хэвлэлийн хангалтыг нэмэгдүүлэн, алслагдсан нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх соёлын явуулын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх а/х авах.	БСШУ-ны сайд
ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ			
101	25.2	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлалтай уялдуулан “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичигт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах;	БХ-ын сайд

102	25.3	Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд гадаадын зарим оронд цэргийн атташе ажиллуулах асуудал боловсруулж, холбогдох шатанд шийдвэрлүүлэх;	БХ-ын сайд
103	25.4	Улсын дайчилгааны нэгдсэн болон яам, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг тодотгох;	БХ-ын сайд
104	25.5	Дайчилгааны тухай хуулийн дагуу төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтны цэрэг-стратегийн бэлтгэл сургалтын арга хэлбэрийг боловсронгуй болгож, сургалтын тасралтгүй байдлыг хангах;	БХ-ын сайд
105	25.6	Дайчилгааны тухай хуулийн дагуу бүх аймаг, нийслэлд дайчилгааны I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгуулж явуулах;	БХ-ын сайд
106	26.3	Чад Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчнээс 800 хүнтэй мотобуудлагын батальон оролцуулах;	БХ-ын сайд
107	26.6	Энхийн үйл явц, терроризмын эсрэг аливаа хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хоёр талын болон олон талын хамтарсан арга хэмжээ, сургалт, дадлага, цэргийн ажиллагаанд идэвхтэй оролцох;	БХ-ын сайд
108	26.8	Цэргийн дайчилгааны нөөцийн зарим хэсгийг бүрдүүлэх, сольж шинэчлэх арга хэмжээ авах;	БХ-ын сайд
109	26.11	Батлан хамгаалахын их сургуулийн удирдлага, зохион байгуулалт, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааны агуулга, технологийг шинэчлэн, батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчний эрэлт хэрэгцээг хангахуйц цэргийн болон иргэний боловсон хүчин бэлтгэх зориулалт бүхий гадаадын өндөр хөгжилтэй орнуудын цэргийн сургуулийн жишиг стандартад нийцүүлж хөгжүүлэх, “Батлан хамгаалахын их сургуулийг 2005-2010 хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсронгуй болгон, хэрэгжүүлэх;	БХ-ын сайд
110	26.14	Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийг Энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургалтын төв болгон өргөжүүлэх;	БХ-ын сайд
111	26.15	Цэргийн эмнэлгийг цогцолбор төв болгон хөгжүүлэх арга хэмжээ авах;	БХ-ын сайд
112	26.16	Зэвсэгт хүчний байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах чиглэлээр зэвсэгт хүчний ангиудтай байлдааны үүргийн болон тусгай үүргийн команд-штабын сургуулиудыг байгуулах.	БХ-ын сайд
113	27.2	НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох анги, салбаруудын зэвсэглэл, техникийг шинэчлэх дэд төсөл боловсруулж хэрэгжүүлэх;	БХ-ын сайд
114	29.3	Улсын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх, галын аюулгүй байдлын техникийн стандарт, дүрэм боловсруулах;	Шадар сайд
115	30.1	ОУИХБ-ын Гүйцэтгэх зөвлөлд Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газрыг гишүүнээр элсүүлэх;	Шадар сайд
116	30.2	Харилцаа, хамтын ажиллагаатай гадаад улс, олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох, хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар ажиллах;	Шадар сайд
117	31.2	Гамшгаас хамгаалах нэгдсэн дадлага, сургуулийг 3 аймагт зохион байгуулах;	Шадар сайд
118	31.3	Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний болон гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, ажилтан, оюутан, сурагч, иргэдийн гамшгаас хамгаалах сургалтын чанарыг сайжруулах;	Шадар сайд
119	31.4	Онцгой байдлын албаны офицер, ахлагч нарыг гадаад улс, олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулах, суралцагсдын тоог нэмэгдүүлэх;	Шадар сайд
120	32.2	Эдийн засгийн бүс, аймаг, сумдын хэмжээнд орон нутгийн гамшгийн нөөцтэй байх чиглэлээр өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Шадар сайд
ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ			
121	33.5	Төрийн бодлого, үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үр нөлөөг дээшлүүлэх;	ЗГХЭГ-ын дарга

122	34.1	Хууль тогтоомж хоорондын зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд иргэн, аж ахуйн чиглэлийн хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгах	ХЗДХ-ийн сайд
123	34.4	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж мөрдүүлэх, хувийн хэвшил, салбар бүрийн жишиг гэрээний төслүүдийг боловсруулах;	ЗГХЭГ-ын дарга
124	34.8	Барилгын салбарын норм, дүрэм, нормативын баримт бичгийг хянаж боловсронгуй болгох, шинэчлэх;	ЗТБХБ-ын сайд
125	34.9	Үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээний уялдааны талаар судалгаа хийж, шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга замыг тодорхойлох;	ХЗДХ-ийн сайд
126	34.12	Улаанбаатар хотод “Холбоо, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээ” төсөл хэрэгжүүлэх;	ЗГХЭГ-ын дарга
127	34.13	Улаанбаатар хотын гудамж, талбай, олон нийтийн газарт телекамер суурилуулах ажлыг иргэд, олон нийтийн туслалцаа, дэмжлэгээр хийж гүйцэтгэх;	ЗГХЭГ-ын дарга
128	34.15	Хүний эрхийн талаархи сургалт, сурталчилгааны ажлыг эрх зүйн албан бус сургалттай уялдуулан нийтэд хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах;	ЗГХЭГ-ын дарга
129	34.17	Террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагаанд оролцох үүрэг бүхий цагдаа, дотоодын цэргийн тусгай нэгж, салбарыг өргөтгөн зохион байгуулах, террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагаа явуулах чиглэлээр цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдыг сургалтад хамруулах;	ХЗДХ-ийн сайд
130	34.18	Садар самуунтай тэмцэх, нэн ялангуяа хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх тусгай чиг үүрэг бүхий цагдаагийн нэгжийг байгуулах;	ХЗДХ-ийн сайд
131	34.22	Цагдаагийн академи, цагдаагийн мэргэжлийн сургалт, судалгааны төвийг шаардлагатай техник, хэрэгслээр хангах;	ХЗДХ-ийн сайд
132	34.23	Хилийн цэргийн дээд сургуульд үндсэн болон давтан сургах дамжааны сонсогчдын дотуур байр барих ажлыг эхлүүлэх;	ХЗДХ-ийн сайд
133	34.26	Иргэний эрх зүйн шинэчлэлийг хийх;	ХЗДХ-ийн сайд
134	34.28	Алт тушаалт, алтны нөөц ашиглалтын лиценз байгаль орчны нөхөн сэргээлтийг шалгах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болсон	БОАЖ-ын сайд, ЭБЭХ-ний сайд
135	35.1	Олон улсын жишиг стандартад нийцсэн архивын нэгдсэн цогцолбор барих ажлыг эхлүүлэх;	ХЗДХ-ийн сайд
136	35.2	Төрийн архивын мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан нэгдсэн сан байгуулах, байгууллагын үйл ажиллагаанд цахим бичиг хэргийн тогтолцоог нэвтрүүлэх;	ХЗДХ-ийн сайд
137	35.3	Цагдаагийн байгууллагын авто парк, зэвсэг, тусгай хэрэгслийн хангалтыг төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар шийдвэрлэх;	ХЗДХ-ийн сайд
138	35.4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэд, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд онцгой анхаарах, нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр ажилладаг цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээ авах;	ХЗДХ-ийн сайд
139	35.7	Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, ялтныг хуульд заасан шаардлага, олон улсын стандарт, жишигт нийцсэн нөхцөлд ял эдлүүлэх, ялтныг нийгэмшүүлэх ажилд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хорих анги, цагдан хорих байруудыг орчин үеийн телекамер, дохиоллын систем, тоног төхөөрөмжөөр хангах;	ХЗДХ-ийн сайд
140	35.8	Улсын хил хамгаалалтад шинэ загварын хянах цамхаг, нисгэгчгүй агаарын хянах хэрэгслийг туршилтын журмаар ашиглах;	ХЗДХ-ийн сайд
141	35.9	Хилийн аюулгүй байдлын мэдээллийн тусгай сан, сүлжээ байгуулах техник, зохион байгуулалтын арга хэмжээ авч, ХХЕГ-т сансрын холбооны суурин станц байгуулах;	ХЗДХ-ийн сайд
142	35.10	Хилийн ангиудыг дохионы бууны сум, туулах чадвар сайтай, техник, эдийн засгийн өндөр үзүүлэлттэй автомашин, бусад техникээр хангах;	ХЗДХ-ийн сайд

143	35.12	Гэмт хэрэгтэй тэмцэх, арга үйлдлийг нотлох ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор гисто-химийн, гарын мөрний, биологийн гаралтай объектууд, ДНХ-ийн шинжилгээний лабораториудыг техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;	ХЗДХ-ийн сайд
144	35.13	Улсын хилийг хамгаалах үүргийг “Мэргэшсэн гэрээт хилчин”-ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх;	ХЗДХ-ийн сайд
145	35.14	“Бүсчилсэн хамгаалалт” төслийг говь, цөлийн бүсэд туршиж, цаашид бусад бүсүүдэд үе шаттайгаар хэрэгжүүлэх;	ХЗДХ-ийн сайд
146	35.16	Монгол Улс, БНХАУ-ын хилийн “Буйр нуур”-ын хэсэгт усан хилийн тэмдэглэл хийж, усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох;	ХЗДХ-ийн сайд
147	35.17	Хилийн зарим заставыг төвлөрсөн эрчим хүчинд холбох;	ХЗДХ-ийн сайд
148	35.18	Хилийн зарим заставыг сэргээгдэх эрчим хүчний 3-5 кВт-ын төхөөрөмжөөр хангах;	ХЗДХ-ийн сайд
149	35.19	Хилийн зарим застав, харуулд шинээр худаг гаргах, усны хатуулаг ихтэй газарт ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих; /	ХЗДХ-ийн сайд
150	35.21	Хилийн боомтын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулах;	ХЗДХ-ийн сайд
151	35.22	Хил хамгаалалтын дэд бүтцийг сайжруулах, анги, салбаруудад ажиллагсдын нийгмийн баталгааг бэхжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авах;	ХЗДХ-ийн сайд
152	35.25	Хилийн заставуудын хашааг шинэчлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;	ХЗДХ-ийн сайд

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖЭЭГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилтын дугаар	Зорилтын агуулга, арга хэмжээ	Хариуцан хэрэгжүүлэгч
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
1	3.9	Нийгмийн даатгалын сангийн бие даасан үйл ажиллагааг дэмжиж, шинэ менежмент нэвтрүүлэх замаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг урт хугацааны хөрөнгө оруулалтад ашиглах эрх зүйн орчныг бий болгох;	СЗХ-ны дарга
БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
2	6.30	“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвийн 2 хувиас багагүй байхаар тооцож төлөвлөх	ХХААХҮ-ийн сайд
3	8.13	Улаанбаатар хотод олон улсын төмөр замын вокзал барих ТЭЗҮ-ийг боловсруулах;	ЗТБХБ-ын сайд
4	8.14	Зүүнхараад ачааны вагоны хос дугуйг эмхлэн угсрах цехийн эхний хэсгийг ашиглалтад оруулах;	ЗТБХБ-ын сайд
5	8.29	ОХУ болон БНХАУ-ыг холбосон манай улсаар дайран өнгөрөх транзит ачааны авто замыг Баян-Өлгий аймгийн Улаанбайшинт-Даянгийн боомтын хооронд гадаадын хөрөнгө оруулалтаар барьж эхлэх;	ЗТБХБ-ын сайд
6	8.31	Тавантолгой-Оюутолгой-Гашуунсухайтын төмөр замыг барих;	ЗТБХБ-ын сайд
7	8.34	Бүх аймаг, сумын төвүүдэд ахуйн үйлчилгээний төв байгуулж ажиллуулах ажлыг хувийн хэвшилд тулгуурлан эхлүүлж төрөөс дэмжлэг үзүүлж, олон улсын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрт хамруулах	ЗТБХБ-ын сайд
8	8.35	Булган аймгийн Булган-Хантай чиглэлийн эрчим хүчний шугамыг барьж байгуулах;	ЭБЭХ-ний сайд
9	6.35	Эргэлтэнд ороогүй газар тариалангийн газрыг эргүүлэн хурааж авах	ХХААХҮ-сайд
БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
10	13.18	Улаанбаатар хотын гэр хорооллыг барилгажуулах зорилгоор 1 жилийн хугацаатай түр оршин суух орон сууцны иж бүрэн хороолол 1-ийг Улаанбаатар хотод барих;	ЗТБХБ-ын сайд
11	15.4	Аймгуудын төвд IP/MPLS технологид суурилсан өндөр хурдны түгээх сүлжээг байгуулах	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО			
12	18.13	Мэдлэгт суурилсан эдийн засагт хүрэх зорилтыг тодорхой болгох зорилгоор аутсорсингийн үйл ажиллагааг эхлүүлэх, ажиллагсдыг бэлтгэх сургалтыг идэвхжүүлэх;	НХХ-ийн сайд, БСШУЯ-ны сайд
ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ			
13	33.13	Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөхийн орон тоог бий болгох;	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга
14	33.14	Хот, тосгоны хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдал, эдийн засгийн хөгжлийн бие даасан байдлыг хангах чиглэлээр Улсын Их Хурлын бүтцэд Түр хороо байгуулж ажиллуулах.	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга
15	34.11	Цахим засаглал хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, цахим засаглалын EGOV.MN хөтөлбөр боловсруулах;	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга
16	34.2	Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх дунд хугацааны хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2011 оны 5 сарын 27 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн Байнгын хороод, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, саналын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070147
tushaal